

“Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн Мониторинг “төслийн явцын тайлан

Төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд:

Сонгогчдын Боловсрол Төв, Глоб Интернэйшнл төрийн бус байгууллагуудаас Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн (Соросын сан) дэмжлэг, санхүүжилтээр Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг төслийг хэрэгжүүлж байна.

Мониторингийн зорилго:

Төслийн гол зорилго нь сонгуулийн кампанит ажлын үеэр телевиз, сонин, сонин хэвлэл болон сонгож авсан сонгуулийн тойргуудад зохиогдох арга хэмжээнд мониторинг хийх замаар төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглаж буй тоо баримт цуглуулан, анализ хийн, ашигласан төрийн эх үүсвэрийн хэмжээг тооцоолон гаргана.

Төслийн үр дүнд сонгуулийн кампанит ажилд төрийн эх үүсвэр ашиглахыг зогсооход чиглэсэн шинэчлэл хийх талаар санал зөвлөмж боловсруулан гаргана.

Түүнчлэн төрийн эх үүсвэрийг улс төрийн зорилгод ашиглахын хор холбогдлын талаар олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах болно.

Мониторинг хийх үндэслэл:

Сонгуулийн кампанит ажилд төрийн санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хэрэгслийг ашиглах, тухайлбал, төрийн албан хаагч, төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэрийг ашиглахгүй байхаар УИХ-ын сонгуулийн тухай хууль, Авилгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Улс төрийн намуудын тухай хуулиудын холбогдох зүйл, заалтуудыг үндэслэн энэхүү мониторингийн ажлыг хийж байна. Тухайлбал:

- УИХ-ын Сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлд сонгууль бэлтгэн явуулах хугацаанд төсөвт болон төрийн өмч оролцсон байгууллагаас хандив авч болохгүй гэж заасан байна.
- Авилгалын тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн албан хаагч албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завшихыг хуулиар хориглосон.
- Төрийн албаны тухай хуулийн 15.1.1-д төрийн албан хаагчаас албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцохгүй байх тухай заажээ.
- Зар сурталчилгааны тухай хуулийн 6.1, 7.1, 7.7-д заасны дагуу далд сурталчилгаа гэж юу болох, 25 дугаар зүйлд заасны дагуу зар сурталчилгаанд тавих олон нийтийн хяналтын талаарх зохицуулалтыг тусгажээ.

Мониторинг хийж буй баг:

Төслийн багийн гишүүдээс Унгарын Будапешт хотноо “Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийг хянах нь” бүсийн сургалтанд хамрагдсанаас гадна олон улсын байгууллагаас зөвлөхүүд урьж ажиллуулснаар уг төслийн аргачлалыг олон улсын стандарт туршлага дээр үндэслэн боловсруулсан. Төслийг хэрэгжүүлэгч баг нь хэвлэл мэдээллийн мониторингийн баг, сонгуулийн арга хэмжээнд төрийн эх үүсвэрийн ашиглалтанд мониторинг хийх баг, дүн шинжилгээ хийх баг гэсэн гурван үндсэн хэсэгтэй ба нийт 40 гаруй гишүүд ажиллаж байна.

Явцын тайлангийн хамрах хугацаа:

Дээрхи төслийн сонгуулийн арга хэмжээнд мониторинг хийх ажил хэвлэлийн бага хурал хийж олон нийтэд танилцуулсны дараагаар буюу 2004 оны 04 сарын 26-ноос эхэлсэн. Тус явцын тайлан 04 сарын 26-ноос 06 сарын 14-ний өдрийг хүртэлх хугацааг хамарч байна.

Үйл ажиллагаа:

Нэг. Арга хэмжээний мониторинг

Мониторингийн энэ хэсэгт сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд /уулзалт, урлагийн тоглолт, сургалт семинари, сурталчилгааны материал тараалт/ төрийн өмчийн байр, төрийн унаа, төрийн албан хаагчийг ашиглаж буй эсэхэд мониторинг хийх зорилготой юм.

Явцын тайлангийн хамрах хугацаанд хот хөдөөгийн (10 аймгийн төв, нийслэлийн 3 дүүрэгт) нийт 13 хэсэгт 170 удаагийн арга хэмжээг ажиглалаа.

Төрийн өмчийн байрыг сонгуулийн кампанит ажилд ашигласан байдал – Нийт 170 арга хэмжээний 98 нь төрийн өмчийн байранд болсон ба түүнээс 75 нь МАХН-ын сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ, 23 нь Эх Орон Ардчилал эвслийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ байв. 62 удаагийн арга хэмжээ төрийн байранд төлбөргүй болсны 53 нь МАХН, 9 нь Эх Орон Ардчилал эвслийн арга хэмжээ, харин төрийн байранд төлбөртэй болсон арга хэмжээний 11 нь МАХН, 13 нь Эх Орон Ардчилал эвслийн арга хэмжээ, төрийн байранд боловч төлбөр төлсөн эсэх нь мэдэгдээгүй арга хэмжээ 12 байснаас 11 нь МАХН-ын, 1 нь Эх Орон Ардчилал эвслийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээ байжээ.

Төрийн албан хаагчийг сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд ашигласан байдал – 170 удаагийн арга хэмжээнд нийтдээ 765 төрийн албан хаагч сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд ашиглагдаж, 3468,4 цагийг зориулжээ. 765 төрийн албан хаагчаас 748 нь МАХН-ын сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд, 17 нь Эх Орон Ардчилал эвслийн сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд оролцжээ.

Төрийн унааг сонгуулийн кампанийн арга хэмжээнд ашигласан байдал – 170 удаагийн арга хэмжээнд 481 төрийн унаа ашиглагдсанаас давхардсан тоогоор 147 нь УБЗ гэсэн дугаартай байжээ. Үлдэх машинууд орон нутгийн төрийн байгууллагуудын унаа байсан байна. Сонгуулийн кампанит ажлын арга хэмжээнд төрийн унаа ашигласан байдлыг намын харьяаллаар нь харвал 478 нь МАХН, 3 нь Эх Орон Ардчилал эвслийн сонгуулийн кампанийн арга хэмжээнд оролцсон байна.

Хоёр. Хэвлэл мэдээллийн мониторинг

Мониторингийн энэ хэсэгт сонгуулийн кампанит ажлын үеэр дор дурьдсан нөлөө бүхий мэдээллийн хэрэгслүүдийн хүрээнд, **Нэгд** төлбөртэй болон далд сурталчилгаанаас бүрдэх нийт сонгуулийн сурталчилгаа, мөн сонгуулийн тэнцвэртэй мэдээллийн тоо хэмжээг тодорхойлох, **Хоёрт** эдгээр төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр баримжаалан үнэлэхийг зорьсон болно:

- **5 телевиз:** Монголын Үндэсний Телевиз, UBS телевиз, MN-25 , TV5, TV9
- **2 радио:** Монголын Үндэсний Радио, Улаанбаатар Радио
- **10 сонин:**
 - Өдөр тутмын 6 сонин: “Зууны Мэдээ”, “Улаанбаатар Таймс”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үнэн”, “Монголын мэдээ”
 - Өдөр тутмын биш боловч олон хувь хэвлэгддэг 4 сонин: “Сэрүүлэг”, “Монголчуудын Амьдрал”, “Хүмүүс”, “Зиндаа”

Нэг. Төлбөртэй болон далд сурталчилгааны тоо хэмжээ

Телевиз: Явцын тайлангийн хугацаанд 5 телевиз 21163,1 минутын төлбөртэй болон далд сурталчилгаа явуулсан байна. Төлбөртэй сурталчилгаа 4050,5 минут, далд сурталчилгаа 16088,6 минут байв. Бодитой тэнцвэртэй мэдээлэл 1024 минут байв.

Радио: Явцын тайлангийн хугацаанд хоёр радио 8567,5 минутын төлбөртэй болон далд сурталчилгаа явуулсан байна. Үүнээс төлбөртэй сурталчилгаа 2547 минут, далд сурталчилгаа 6020,5 минут байв. Бодитой тэнцвэртэй мэдээлэл 109 минут гэж бүртгэгдсэн байв.

Сонин: Явцын тайлангийн хугацаанд 10 сонин 6698,8 дециметр квадратын төлбөртэй болон далд сурталчилгаа явуулсан байна. Үүнээс төлбөртэй сурталчилгаа 784,1 дециметр квадрат, далд сурталчилгаа 5914,7 дециметр квадрат байв. Бодитой тэнцвэртэй мэдээлэл 1878,3 дециметр квадрат гэж бүртгэгдсэн байв.

Хоёр. Төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр баримжаалан үнэлэх

Нийт төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр баримжаалан үнэлбэл 1703448120 (1 тэрбум 700 гаруй сая) төгрөг болж байна. Ийнхүү тооцохдоо нэгжийн үнийг хэвлэл мэдээллийн албан ёсны төлбөрүүдийн доод хязгаарыг сонгож авсан ба энэ нь зөвхөн нийт сурталчилгааг мөнгөн дүнгээр баримжаалан илэрхийлэх зорилготой юм.

Телевиз: Явцын тайлангийн хугацаанд 1242,139,000 (1 тэрбум 240 гаруй сая) төгрөгөөр үнэлэгдэх төлбөртэй болон далд сурталчилгааг явагдсанаас төлбөртэй нь 149,950,000 (149 сая гаруй) төгрөг, далд нь 1,092,189,000 (1 тэрбум 92 сая гаруй) төгрөгөөр үнэлэгдэж байна гэсэн тооцоо гарлаа. МҮТВ, UBS телевизээр 494,700,000 (494 сая гаруй) төгрөгөөр үнэлэгдэх сурталчилгаа хийгдсэнээс төлбөртэй нь 59650000 (59 сая гаруй), далд нь 435050000 (435 сая гаруй) төгрөг гэсэн тооцоо гарлаа.

Радио: Явцын тайлангийн хугацаанд мониторингт хамрагдсан 100 хувь төрийн өмчийн хоёр радиогоор 390,650,000 (390 сая гаруй) төгрөгийн сурталчилгаа явагдсанаас төлбөртэй нь 70,944,000 (70 сая гаруй) төгрөг, далд нь 319,706,000 (319 сая гаруй) төгрөгөөр үнэлэгдэж байна.

Сонин: Явцын тайлангийн хугацаанд мониторингт хамрагдсан 10 сониноор 70659120 (70 гаруй сая) төгрөгийн сурталчилгаа нийтлэгдсэнээс төлбөртэй нь 3158740 (3 сая гаруй), далд нь 67500380 (67 сая гаруй) төгрөгөөр үнэлэгдэж байна.

Давтан хэлэхэд эдгээр дүнгүүд нь нийт сурталчилгааг зөвхөн мөнгөн дүнгээр баримжаалан илэрхийлэх зорилготой гаргасан үнэлгээ юм

Монголын парламентын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг




Сонгогчдын Боловсрол Төв

Глоб Интернэшнл ТББ


ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

2004.4.26 - 6.13


Телевизийн сувгуудаар намууд болон тэнцвэртэй мэдээлэл гарсан байдал




Телевизийн далд сурталчилгаа: шалгууруудаар




Телевизийн далд сурталчилгаа : сувгуудаар




Телевизийн төлбөртэй болон далд сурталчилгааны динамик



Телевизийн төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр илэрхийлвэл



Радиоогоор намууд болон тэнцвэртэй мэдээлэл гарсан байдал




- МАХН
- Эх орон-Ардчилал Эвсэл
- Бусад нам, эвсэл
- Тэнцвэртэй мэдээлэл

Радиоогоор нэвтрүүлсэн далд болон төлбөртэй сурталчилгаа




Радиоогоор нэвтрүүлсэн далд сурталчилгаа: шалгууруудаар



Радиоогоор нэвтрүүлсэн далд сурталчилгаа : сувгуудаар




Радиоогоор нэвтрүүлсэн төлбөртэй болон далд сурталчилгааны динамик




Радиоогоор нэвтрүүлсэн төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр илэрхийлвэл



Сонинуудад намууд болон тэнцвэртэй мэдээлэл гарсан байдал



Сонинуудад хэвлэгдсэн далд сурталчилгаа : шалгууруудаар




■ МАХН

■ Эх орон-Ардчилал Эвсэл

■ Бусад нам, эвсэл

■ Бие даан нэр дэвшигчид

СОНИН дахь далд сурталчилгаа: шалгууруудаар



Сонинуудад хэвлэгдсэн далд сурталчилгаа : өдөр тутмын сонинуудаар



■ МАХН ■ Эх орон-Ардчилал Эвсэл
■ Бусад нам, эвсэл ■ Бие даан нэр дэвшигчид


Бусад сонинуудад хэвлэгдсэн далд сурталчилгаа : өдөр тутмын биш боловч ОЛОН ХУВЬ НИЙТЛЭГДДЭГ



Сонинуудад хэвлэгдсэн тэнцвэртэй МЭДЭЭЛЭЛ



Сонинуудад хэвлэгдсэн төлбөртэй болон далд сурталчилгааны динамик



Сонинуудад хэвлэгдсэн нэвтрүүлсэн төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр илэрхийлвэл




Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан төлбөртэй болон далд сурталчилгааг тогрогоор илэрхийлвэл



■ МАХН
 ■ Эх орон-Ардчилал Эвсэл
 ■ Бусад нам, эвсэл
 ■ Бие даан нэр дэвшигчид

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан төлбөртэй болон далд сурталчилгааг төгрөгөөр болон сонгуульд өрсөлдөгч субъектүүдээр



**Сонгуулийн кампанит ажлын арга
ХЭМЖЭЭНИЙ МОНИТОРИНГ
2004.04.26-2004.06.14**


**10 аймгийн төв,
нийслэлийн 3**

дүүрэгт нийт 170


удаагийн арга


ХЭМЖЭЭГ

ажигласан.



Арга хэмжээ зохион байгуулсан байрны өмчийн харьяалал






□ төрийн байранд үнэгүй


■ төрийн байранд үнэтэй

■ төрийн байранд үнэтэй эсэхийг мэдэж чадаагүй


Төрийн өмчийн байрыг намууд ашигласан байдал




Төрийн өмчийн байрыг намууд төлбөргүй ашигласан байдал




Төрийн өмчийн байрыг намууд төлбөртэй ашигласан байдал



Төрийн өмчийн байрыг намууд төлбөртэй ашигласан эсэхийг мэдэж чадаагүй байдал






481 - төрийн унаа сонгуулийн
кампанит ажилд ашиглагдсан.


Түүнээс:

141 - УБЗ дугаартай байна.

Төрийн унааг намууд ашигласан байдал




- **765** төрийн албан хаагч сонгуулийн кампанит ажилд албан хаагчийн хувиар оролцсон.



3468.4 цагийг мониторинг
хийсэн **170** сонгуулийн кампанит
ажилд зарцуулжээ.

● **3468.4 = 145**

ХОНОГ



■ МАХН

■ Эх Орон-Ардчилал эвсэл